ВИДЕО МЭДЭЭ · 2024 оны 3-р сарын 20

НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ 2023 ОНД ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ 50.2%-ИАР, ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ 39%-ИАР ӨССӨН БАЙНА



Налайх, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 онд 1200 орчим гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оноос 50,2 хувиар, 92 мянга орчим зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 39 хувиар өссөн байна. Зуны улиралд Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн байгалийн цогцолборт газар болох Горхи-Тэрэлжийн амралт, аялал жуулчлалын бүсэд гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг бол цахим залилангийн гэмт хэрэг нийтлэг үйлдэгдэх болжээ.

Налайх, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрээр зүүн болон говийн бүс рүү явдаг босоо тэнхлэгийн зам дайран өнгөрдөг учир замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих зөрчил ихээр үйлдэгджээ. Тиймээс 2024 онд тухайн зөрчлийн хэргийг бууруулах, мөн хүний халдашгүй байдлын эсрэг болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллаж байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=ssAZSjcfaH8

Тус дүүргийн прокурорын газраас төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад онцгой анхаарч, Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдийн

бодит нөхөн төлбөрийг улсад төвлөрүүлэхэд хяналт тавьж ажилласан нь үр дүнгээ өгчээ.

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиглэлээр нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хүмүүсийг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангасан хувцас хэрэгслээр хангах, хорих ялаас хугацааны өмнө суллагдсан иргэдийг нийгэмд амьдрах, дасан зохицох нөхцөл боломжоор дэмжих зэрэг ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дууссан хүний хилээр нэвтрэх эрхийг сэргээгээгүй 18 зөрчлийг илрүүлж, хилийн хоригийг цуцлуулжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1492